



## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 0172

Улаанбаатар хот

### С.Даваадоржид сахилгын шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.4, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 1.3.1, 1.3.3, 6.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1, 10.9, 10.10.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын ахлах бүртгэгч Самбуугийн Даваадорж албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн нь дотоод хяналт шалгалт болон өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөр тасалбар болгон төрийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. С.Даваадоржийн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Иргэний улсын бүртгэлийн газар (Т.Төгөлдөр)-т, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар (Ж.Аюуш)-т, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар (Б.Ариунболд)-т, хяналт шалгалт, зөрчлийн нэгдсэн санд нэвтрэх эрх цуцлахыг Хяналт шалгалтын газар (Н.Анхбаяр)-т тус тус даалгасугай.

3. Төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг сануулахыг нэгжийн нууц хамгаалах ажилтан (Г.Анхныбаяр)-д үүрэг болгосугай.

4. С.Даваадоржийн ажлыг зохих журмын дагуу хүлээлцэж 590 дугаартай улсын ахлах бүртгэгчийн тэмдэг, 098 дугаартай хяналтын улсын байцаагчийн тэмдгийг хүлээн авч хадгалахыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс (Л.Бальдирмаа)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Д.Давааням)-т тус тус үүрэг боглосугай.

142500518

5.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл улсын ахлах бүртгэгч С.Даваадоржид тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



У.БОЛДХҮҮ